



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН МЕГА ТӨСЛҮҮДИЙН ТОЙМ ЗУРАГЛАЛ



БОЛОВСРУУЛСАН: А.БАТПҮРЭВ

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САР

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
1. ТАНИЛЦУУЛГА	4
2. МЕГА ТӨСЛҮҮДИЙН ХУРААНГУЙ ЗУРАГЛАЛ	5
2.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
2.2 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ	7
2.3 ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ.....	8
3. ТӨСЛҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС.....	12
4. ОС4IDS, PIMA АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ	15
4.1 АРГАЧЛАЛУУДЫН ТУХАЙ	15
4.2 МЭДЭЭЛЛИЙН ХЯЗГААРЛАЛТ	16
4.3 ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	17
5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	18
ХАВСРАЛТ 1	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

FPIC	Free Prior Informed Consent
IMF	International Monetary Fund
JSON	JavaScript Object Notation
OC4IDS	Open Contracting for Infrastructure Data Standard
ОСР	Open Contracting Partnership
OCDS	Open Contracting Data Standard
PIMA	Public Investment Management Assessment
ААН	Аж ахуйн нэгж
БОННУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон нийслэл Улаанбаатар хотоос 2024-2040 он хүртэл хугацаанд нийт 38 мега төслийг хэрэгжүүлэхээр зарласан.

Эдгээр төслийн эдийн засгийн үндэслэл, нийгмийн үр нөлөө, хэрэгжилтийн явц, санхүүжилтийн үндэслэл, хууль эрх зүйн дагалдах процесс, олон нийтэд нээлттэй байдлын түвшинд бодит үнэлгээ хийх нь нийгмийн ойлголцол, хөрөнгө оруулалт татах боломж зэргийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын төр засгийн том хэмжээний төсөл хэрэгжүүлэх чадавхыг сайжруулахад ач холбогдолтой.

Тиймээс энэхүү тайланд уг 38 төслийн албан ёсны эх сурвалжаас авсан, нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн тойм зураглал гаргаж, нэгтгэн үнэлэхийг зорив. Зураглалын үр дүн нь иргэд, судлаачид, бодлого боловсруулагчид болон хөрөнгө оруулагчдад зориулагдсан бөгөөд олон нийтэд нээлттэй, харьцуулж болохуйц мэдээлэлд суурилсан анхны нэгдсэн тойм юм. Тойм зураглалаар төсөл тус бүрийн дараах 3 бүлэг 20 мэдээллийг нэгтгэсэн. Үүнд:

А. Ерөнхий мэдээлэл:

1. Төслийн нэр, зорилго, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үе шат
2. Байршил
3. Үйл ажиллагааны салбар
4. Төсөл баталсан шийдвэр, огноо
5. Төсөл хэрэгжүүлэгч, хуулийн этгээдийн хэлбэр
6. Техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн эсэх
7. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу "Улсын дунд хугацааны (2021-2025) хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т туссан эсэх

В. Төсөв, санхүүгийн мэдээлэл:

8. Батлагдсан төсөв
9. Санхүүжилтийн эх үүсвэр
10. Засгийн газрын баталгаа, батлан даалт гаргасан эсэх
11. Зарцуулалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээлэл
12. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
13. Төслийн хэрэгжилттэй холбоотой худалдан авалтын төлөвлөгөө, сонгон шалгаруулалтын мэдээлэл
14. Ханган нийлүүлэх гэрээ, түүний дүн, хугацаа, ханган нийлүүлэгчдийн жагсаалт, тэдгээрийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

С. Төслийн үйл ажиллагааны мэдээлэл:

15. Төслийн хэрэгжилтийн байдал
16. Үйл ажиллагааны тайлан нийтэлсэн эсэх
17. Шаардлагатай зөвшөөрлүүд авагдсан байдал
18. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан
20. Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын мэдээлэл

Төслүүдийн ерөнхий үнэлгээг хийхдээ Open Contracting for Infrastructure Data Standard (OC4IDS), IMF Public Investment Management Assessment (PIMA) аргачлалуудыг ашиглав. Гэвч эдгээр аргачлалын хүрээнд шаардагдах олон төрлийн мэдээлэл нь авч үзэж буй ихэнх төслийн хувьд дутуу эсвэл нээлттэй бус байгаа тул аргачлалуудын дагуу иж бүрэн үнэлгээ хийх боломжгүй, зөвхөн тойм харьцуулалт хийхээс өөр аргагүй байв.

Төслүүдийн өгөгдлийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт файлд нэгтгэсэн бөгөөд мэдээлэл тус бүрд холбогдох нийтэд нээлттэй эх сурвалжийн холбоосыг мөн шаардлагатай хэсэгт оруулсан.

2. МЕГА ТӨСЛҮҮДИЙН ХУРААНГУЙ ЗУРАГЛАЛ

Засгийн газар болон нийслэлээс хэрэгжүүлэх мега төслүүдийг хураангуй байдлаар зураглавал дараах байдалтай байна. Үүнд:

2.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслүүдийн үндсэн зорилго:

- Хотын түгжрэлийг бууруулах – 9 төсөл
- Агаарын бохирдлыг бууруулах – 8 төсөл
- Нийгмийн дэд бүтцийг сайжруулах – 6 төсөл
- Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх – 5 төсөл
- Эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх – 4 төсөл
- Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх – 3 төсөл
- Бусад (судалгааны, нөөцийн үнэлгээ гэх мэт) – 3 төсөл

Байршил (давхардсан):

- Улаанбаатар хот – 24 төсөл
- Өмнөговь аймаг – 4 төсөл
- Дорнод аймаг – 2 төсөл
- Бусад (Дархан, Булган, Ховд, Дорноговь гэх мэт) – 8 төсөл

Үйл ажиллагааны салбар:

- Хот байгуулалт – 11 төсөл
- Зам, тээвэр – 10 төсөл
- Нийгмийн дэд бүтэц, байгаль орчин – 8 төсөл
- Эрчим хүч – 5 төсөл
- Уул уурхай – 4 төсөл

Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн хэлбэр:

- ОНӨААТҮГ, Орон нутгийн өмчит ААН – 10 төсөл
- ТӨХК (Төрийн өмчит хувьцаат компани) – 8 төсөл
- ТӨҮГ (Төрийн өмчит үйлдвэрийн газар) – 7 төсөл
- Бусад (холимог болон ТХХТ-ээр хэрэгжүүлэгч) – 13 төсөл

ТЭЗҮ хийгдсэн байдал

38 мега төслөөс 22 төслийн ТЭЗҮ хийгдсэн бол бусад 16 төсөлд ТЭЗҮ хийгдээгүй эсвэл тодорхойгүй байна.

Хүснэгт 1. Мега төслүүдийн ТЭЗҮ хийгдсэн байдал

	ТЭЗҮ (урьдчилсан ТЭЗҮ) хийгдсэн	ТЭЗҮ хийгдээгүй	Мэдээлэл тодорхойгүй
Засгийн газрын 14 төсөл	10 төсөл (71%)	2 төсөл (14%)	2 төсөл (14%)
Нийслэлийн 24 төсөл	12 төсөл (50%)	12 төсөл (50%)	
Нийт	22	14	2

ТЭЗҮ хийгдсэн төслүүд:

1. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам
2. Газрын тос боловсруулах үйлдвэр
3. Уран олборлох төсөл
4. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор
5. Зэс боловсруулах цогцолбор
6. Гангийн цогцолбор
7. Эрдэнэбүрэнгийн 90 мвт-ын усан цахилгаан станц
8. Тавантолгойн 450 мвт-ын дулааны цахилгаан станц
9. Эгийн голын 310 мвт-ын усан цахилгаан станц
10. Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах хоолой барих
11. Туулын хурдны зам
12. Шинэ тойрог зам
13. ДЦС-5
14. Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх
15. “Баянхошуу хот” орон сууцжуулах төсөл
16. “Сэлбэ хот” орон сууцжуулах төсөл
17. “Хүннү хот” (хэсэгчилсэн)
18. “Эмээлт” эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц
19. Улаанбаатар метро
20. Дүүжин замын тээвэр
21. Багахангай-Хүннү чиглэлийн салбар төмөр зам
22. Баруун Далай орд¹

Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан эсэх:

Ихэнх мега төсөл улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтаагүй байна. Тухайлбал,

- Засгийн газрын 5 төсөл хөтөлбөрт багтсан, 9 нь багтаагүй.
- Улаанбаатар хотын 1 төсөл багтсан, 23 нь тус хөтөлбөрт хамрагдаагүй.

Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дараах төслүүд багтсан байна. Үүнд:

1. Газрын тос боловсруулах үйлдвэр
2. Зэс боловсруулах цогцолбор
3. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц
4. Тавантолгойн дулааны цахилгааны станц
5. Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр
6. Дүүжин замын тээвэр

¹ <https://user.tender.gov.mn/mn/result/detail/1729028367216>

2.2 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Мега төслүүдийн төсөв

Засгийн газрын 14 мега төслийн нийт төсөв 37 их наяд төгрөгөөр тооцогдож байгаа бол нийслэлийн 24 төслийн төсөв 55.6 их наяд төгрөг байна.² Үүнээс 9 төслийн батлагдсан төсөвт өөрчлөлт орсон тухай ямар нэг байдлаар мэдээлсэн байна.

Хүснэгт 2. Мега төслүүдийн төсөв

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл
Нийт төсөв ³	~37.3 их наяд төгрөг	~55.6 их наяд төгрөг
Дундаж төсөв	2.6 их наяд төгрөг	2.3 их наяд төгрөг
Хамгийн их төсөвтэй төсөл	Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам 6.795 их наяд төгрөг	Улаанбаатар метро 15.9 их наяд төгрөг
Хамгийн бага төсөвтэй төсөл	Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор – 357.6 тэрбум төгрөг	Олон улсын зочид буудал – 71.5 тэрбум төгрөг

Санхүүжилтийн төлөвлөсөн эх үүсвэр

Засгийн газрын 14 мега төслөөс 6 төслийг нь төрийн өмчит ААН-ээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Харин нийслэлийн 24 төслөөс 10-ыг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлэхээр байна.

Хүснэгт 3. Мега төслүүдийн санхүүжилтийн төлөвлөсөн эх үүсвэр

	Төлөвлөсөн эх үүсвэр (давхардсан тоогоор)	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл
1	Төрийн өмчит ААН	6	1
2	Төсвийн хөрөнгө оруулалт	1	6
3	Гадаад зээл	4	9
4	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	2	0
5	Хөгжлийн банкны зээл	1	0
6	Төр, хувийн хэвшлийн түншлэл	4	10
7	Хувийн ААН	1	0
8	Гадаад тусламж		1
9	Бусад (тодорхойгүй)	5	3
Төлөвлөсөн эх үүсвэрийн тоо (давхардсан)		24	30
Нэг төсөлд ногдох дундаж		1.7	1.3
Санхүүжилт баталгаажсан ⁴ төслийн тоо		5	10
Баталгаажсан төсвийн дүн		~14.1 их наяд ₮	~16.8 их наяд ₮
Санхүүгийн эх үүсвэр баталгаажгаагүй		9	14
Эх үүсвэр баталгаажгаагүй төсвийн дүн		~23.2 их наяд ₮	~38.8 их наяд ₮

² Төсөл тус бүрийн мэдээллээс судлаач нэгтгэсэн дүн

³ Валютын ханшийг 2025.6.13-ны өдрийн Монголбанкны хаалтын ханшаар тооцсон

⁴ Судлаачийн олж авсан, нийтэд ил мэдээллийн хүрээнд тооцсон

Мега төслүүдийн төсөв, санхүүгийн мэдээллийн тухайд дараах анхаарах асуудал байна. Үүнд:

- Засгийн газрын баталгаа, батлан даалт байгаа эсэх талаарх мэдээлэл аль ч төслийн хувьд нээлттэй бус.
- Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцаас бусад төслийн зарцуулалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээлэл ил бус, тодорхойгүй.
- Дээрх хоёр төсөл болон “Эмээлт” аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн төслөөс бусад төслийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт нээлттэй бус.
- Засгийн газрын 4, нийслэлийн 4 төслийн хэрэгжилттэй холбоотой худалдан авалтын төлөвлөгөө, сонгон шалгаруулалтын мэдээлэл Шилэн дансны системээс олдсон бол бусад төсөлтэй холбоотой энэ төрлийн мэдээлэл тодорхой бус, нийтэд ил биш байна.
- Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, “Баянхошуу хот” орон сууцжуулах төслийн ханган нийлүүлэх гэрээ, түүний дүн, хугацаа, ханган нийлүүлэгчдийн жагсаалт хэсэгчилсэн байдлаар ил болсноос өөр бусад төслийн энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нийтэд нээлттэй бус.

2.3 ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Төслийн хэрэгжилтийн байдал

Засгийн газрын 14 мега төслөөс 6 нь хэрэгжиж эхэлсэн бол нийслэлийн 24 төслөөс 5 нь хэрэгжиж эхэлсэн байна.

Хүснэгт 4. Төслийн хэрэгжилтийн байдал

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл	Нийт
Хэрэгжилт эхэлсэн	6	5	11
Хэрэгжилтийн бэлтгэл	4	5	9
Судалгаа, төлөвлөлтийн шатанд	4	14	18

Дараах төслүүд хэрэгжиж эхэлсэн байна. Үүнд:

1. Гашуунсухайт-Ганцмодны боомтын хил дамнасан төмөр зам.
2. Газрын тос боловсруулах үйлдвэр
3. Ураны төсөл
4. Зэс боловсруулах цогцолбор
5. Гангийн цогцолбор
6. Эрдэнэбүрэнгийн 90 мвт-ын усан цахилгаан станц
7. “Баянхошуу хот” орон сууцжуулах төсөл
8. “Сэлбэ хот” орон сууцжуулах төсөл
9. “Эмээлт” эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц
10. Дүүжин замын тээвэр
11. Багахангай-Хүннү хот чиглэлийн салбар төмөр зам

Үйл ажиллагааны тайлан байгаа эсэх:

Засгийн газрын мега төслүүдээс 1 төсөл, нийслэлийн мега төслүүдээс 1 төсөл үйл ажиллагааны тайлангаа өөрийн веб сайтад ил нийтэлсэн байна. Үүнд:

1. Газрын тос боловсруулах үйлдвэр⁵
2. “Эмээлт” эко аж үйлдвэрийн парк⁶

⁵ <https://mongolrefinery.mn/>

⁶ <https://www.emeelpark.mn/single/41>

Хүснэгт 5. Үйл ажиллагааны тайлан гаргасан байдал

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл	Нийт
Үгүй	13	23	36
Тийм	1	1	2

Хөрөнгө оруулалтын төслүүдэд тавигддаг нийтлэг шаардлага

Монгол Улсын төсвийн тухай хуульд⁷ төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд дараах нийтлэг шаардлагуудыг тавьсан бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслүүдийн урьдчилсан үнэлгээг хийж, төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, тусламж зэрэг санхүүжилтийн эх үүсвэрийг эрэмбэлэн тогтооно гэж заасан байдаг.

29^l дүгээр зүйл. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага

29^l.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:

29^l.2.1. тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

29^l.2.2. барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

29^l.2.3. техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;

29^l.2.4. үрсгал зардал гарах төслийн үрсгал зардлыг тооцсон байх;

29^l.2.5. тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай үялдсан байх;

29^l.2.6. олон нийтээр хэлэлцүүлсэн байх.

Мөн түүнчлэн **Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар**⁸ хөгжлийн бодлогын баримт бичгүүд буюу түүнд хамаарах хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийн иж бүрэн, ил тод бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж нийтэд ил болгох чиглэлээр дараах зохицуулалтыг тусгасан байдаг.

22.1.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг үялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.

22.2.Мэдээллийн нэгдсэн санд эрх бүхий байгууллагын баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнтэй холбогдох тайлан, судалгаа, шинжилгээ, тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлнэ.

22.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь холбогдох эрх зүйн акт, тайлан, дүгнэлт, судалгаа, шинжилгээ, баримтаар баталгаажсан байна.

23.1.Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

23.2.Салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор төрийн захиргааны төв байгууллага өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

⁷ <https://legalinfo.mn/mn/detail/12254>

⁸ <https://legalinfo.mn/mn/detail/15403>

Дээрх хуулийн зохицуулалтад туссан зарим гол шаардлагын хэрэгжилтийг Засгийн газрын 14, нийслэлийн 24 мега төслийн нээлттэй мэдээллийн хүрээнд авч үзвэл дараах байдал ажиглагдаж байна.

Шаардлагатай зөвшөөрлүүд авсан эсэх:

Нийтэд ил байгаа мэдээллээс үзэхэд Засгийн газар 10 мега төсөлдөө зөвшөөрөл авсан бол нийслэл зөвхөн 1 төсөлдөө зохих зөвшөөрлийг авсан тухай мэдээлсэн байна. Монгол Улсын төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь “29¹.2.1. тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх” шаардлага тавьсан байдаг бөгөөд төслүүдийн онцлогоос хамааран барилга байгууламж, ашигт малтмал ашиглах, олборлох гэх мэт олон янзын зөвшөөрөл шаардагддаг. Аль төсөлд ямар зөвшөөрөл шаардлагатай, түүнийг бүрэн авсан эсэхийг үнэлэх нь энэ ажлын хүрээнд багтаагүй бөгөөд зөвхөн нийтэд мэдээлсэн байдлыг тоймлов.

Хүснэгт 6. Шаардлагатай зөвшөөрлүүд авсан байдал

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл	Нийт
Тийм	10	1	11
Үгүй	2	3	5
Тодорхойгүй	2	20	22

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн эсэх:

Нийт 38 төслөөс байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг Засгийн газрын 4 төсөл, нийслэлийн 3 төсөл хийлгэсэн тухайгаа нийтэд мэдээлсэн боловч Ураны төслөөс бусад төслийн БОННУ-тэй танилцах онлайн хуудас олдоогүй. Харин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн мэдээллийн сангаас БОННУ хийж буй тухай мэдээ эсвэл тендерийн сонгон шалгаруулалтын зар олдсоныг footnote линкээр оруулав. Эдгээр төслийг дурдвал:

1. Гангийн цогцолбор⁹
2. Эрдэнэбүрэнгийн 90 мвт-ын усан цахилгаан станц¹⁰
3. Ураны төсөл¹¹
4. Газрын тос боловсруулах үйлдвэр¹²
5. Дулааны цахилгаан станц 5¹³
6. “Эмээлт” эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц¹⁴
7. Улаанбаатар метро¹⁵

Хүснэгт 7. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн байдал

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл	Нийт
Тийм	4	3	7
Үгүй	2	6	8
Тодорхойгүй	8	15	23

⁹ <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1684376009295>

¹⁰ <https://eic.mn/envimpact/more.php?reportid=7584>

¹¹ <https://badrakhenergy.com/%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b3%d0%b0%d0%bb%d1%8c-%d0%be%d1%80%d1%87%d0%b8%d0%bd/>

¹² <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1746497924953>

¹³ <https://eic.mn/envimpact/more.php?reportid=5334>

¹⁴ <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1689412648433>

¹⁵ <https://ulaanbaatar.mn/news/21137>

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан байгаа эсэх:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлангаа ил болгосон төсөл алга байна. Зарим төслийн хувьд хийлгэж буй эсвэл хэлэлцүүлж буй гэх мэт мэдээлэл олдсон боловч үр дүнг нийтлээгүй байх тул тодорхойгүй гэсэн ангиллаар бүртгэлээ.

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан боловсруулж нийтэлсэн байдал

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл	Нийт
Тийм	0	0	0
Үгүй	2	6	8
Тодорхойгүй	12	18	30

Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын мэдээлэл нээлттэй эсэх:

Засгийн газрын 3 төсөл, нийслэлийн 6 төсөл л төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын мэдээллээ нийтэлсний дийлэнх нь тендер зарлаж сонгон шалгаруулсан тухай Шилэн дансны мэдээлэл байв.

1. Гашуун сухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын холболт¹⁶
2. Газрын тос боловсруулах үйлдвэр¹⁷
3. Ураны төсөл¹⁸
4. Туулын хурдны зам¹⁹
5. Баянхошуу хот орон сууцжуулах төсөл²⁰
6. Сэлбэ хот²¹
7. Улаанбаатар метро²²
8. Багахангай-Хүннү хот салбар төмөр зам²³
9. “Эмээлт” эко аж үйлдвэрийн парк²⁴

Хүснэгт 9. Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын мэдээллийн нээлттэй байдал

	Засгийн газрын 14 төсөл	Нийслэлийн 24 төсөл	Нийт
Тийм	3	6	9
Үгүй	0	6	6
Тодорхойгүй	11	8	19

Төслүүдийн өгөгдлийн дэлгэрэнгүй хүснэгтийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

¹⁶ <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1743478489121>

¹⁷ <https://www.tender.gov.mn/mn/client/detail/1519221320462?page=1&perPage=20>

¹⁸ <https://badrakhenergy.com/%d0%b7%d3%a9%d3%a9%d0%b2%d1%87-%d0%be%d0%b2%d0%be%d0%be-%d1%82%d3%a9%d1%81%d3%a9%d0%bb-copy/>

¹⁹ <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1731911784681>

²⁰ <https://www.tender.gov.mn/mn/client/detail/1649048560863?page=1&perPage=20>

²¹ <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1721551712472>

²² <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1726456870665>

²³ <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1743569926253>

²⁴ <https://www.emeelpark.mn/single/103>

3. ТӨСЛҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

Засгийн газрын 14 мега төсөл нь 2024 оны 8 дугаар сарын 27-нд батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 21 дүгээр тогтоолд орсон. Харин 24 мега төслийг нийслэл Улаанбаатар хотын түвшинд хэрэгжүүлэхээр Ерөнхий сайд болон нийслэлийн удирдлага зарласан боловч одоогоор төслүүдийг баталсан талаарх нийтэд нээлттэй ямар нэг баримт бичиг байхгүй. “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд эдгээр төслийг хэрэгжүүлнэ гэж буй боловч уг төлөвлөгөө нь УИХ-аар хараахан батлагдаагүй.

Мега төслүүдийг хэрэгжүүлэх шийдвэр, төлөвлөлт, хэрэгжилтийн үйл явц нь Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхой зохицуулагдсан байх шаардлагатай. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар²⁵ төрийн бүх түвшний хөгжлийн бодлого, төслийг боловсруулж батлах, хэрэгжүүлэх, хянах харилцааг ерөнхийд нь зохицуулж байна. Засгийн газар болон нийслэлээс зарласан мега төслүүдийн төлөвлөлт, баталгаажуулалтын процесс нь уг хуулийн зарим шаардлага, үе шат, зарчимтай нийцэхгүй байгаа нь энэхүү зураглалаас харагдаж байна.

Тухайлбал хуулийн 10 дугаар зүйлд зааснаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг дараах үе шаттайгаар боловсруулагдах ёстой. Үүнд:

- Улсын хэмжээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;
- Хөгжлийн загвар, төсөөлөл, үр нөлөө, эх үүсвэрийн судалгаа, тооцоо хийх;
- Урьдчилсан эдийн засгийн, нийгмийн, хүний хөгжил, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх;
- Хувилбаруудын үр ашгийн тооцоонд үндэслэн сонголт хийх;
- Зорилго, зорилтыг үе шаттай тодорхойлох;
- Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон бодлогын баримт бичиг боловсруулах.

Дээрх үе шатуудын хэрэгжилт, тухайлбал нөхцөл байдлын дүн шинжилгээ, бодлогын хувилбарын сонголт, үр нөлөө, эрсдэлийн үнэлгээтэй холбоотой мэдээлэл нь олон төслийн хувьд ил тод бус, зарим тохиолдолд огт байхгүй байна. Жишээлбэл, нийслэлийн 24 төслийн ихэнх нь УИХ, ИТХ-ын шийдвэрээр батлагдаагүй (эсвэл батлагдсан тухай мэдээлэл ил болоогүй) бөгөөд тухайн төслүүдийн хэрэгцээ, үр нөлөөний үндэслэл нь олон нийтэд танилцуулагдаагүй, судалгаа, баримтаар дэмжигдээгүй байна.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар хөгжлийн бодлогын баримт бичигт дараах шаардлага тавигдах ёстой. Үүнд:

- Зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үр дүн,
- Санхүүгийн эх үүсвэр, хариуцах байгууллага,
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо,
- Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр нөлөөний үнэлгээ багтах ёстой.

Эдгээр шаардлагын ихэнх нь, ялангуяа үр нөлөө, санхүүжилтийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, хариуцлагын тогтолцоо мега төслүүдийн бүртгэлд тусгагдаагүй байна. Зарим төсөлд санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэр тодорхойгүй, байгаль орчны үнэлгээ хийгдээгүй бөгөөд хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлага тодорхой биш байна.

Хуулийн 5 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн 17 зарчмаас дараах зарчмууд мега төслүүдийн хувьд ямар нэг байдлаар зөрчигдсөн буюу хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

²⁵ 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан (<https://legalinfo.mn/mn/detail/15403>).

Зарчмын нэр	Үнэлгээ
Нэгдмэл, цогц, уялдаатай байх	Төслийн хувьд уялдаа сул, олон төслийн нийтлэг ерөнхий зорилготой тул хоорондоо давхацсан гэж үзэж болохуйц байна.
Ил тод, нээлттэй байх	Төслүүдийн мэдээллийн тойм зураглалаас үзэхэд дийлэнх агуулгын хувьд төслүүдийн 60 гаруй хувьд тодорхой мэдээлэл байхгүй болон ил бус байна.
Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх	Бодлогын хувилбар, дүн шинжилгээ, үнэлгээ хангалтгүй.
Санхүүгийн эх үүсвэрт үндэслэсэн байх	25 гаруй их наяд төгрөгийн төсөвтэй төслүүдийн санхүүжилт баталгаажаагүй.
Бүх талын оролцоог хангах	Олон нийтийн зөвшилцлийн баримт бичиг төслүүдийн 60 хувьд бүртгэгдээгүй
Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах	ТХХТ-ээр хэрэгжих олон төсөлд сонгон шалгаруулалтын мэдээлэл ил биш.

Төслүүдэд шинээр өөрчлөлт орсон эсэх:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн “Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 28 тоот тогтоолыг²⁶ баталсан байна. Үүнд:

1. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах талаар санал боловсруулан 2025 оны 3 дугаар улиралд багтаан;
2. Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг батлуулан, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, явц, үр дүнг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан;
3. Багануурын уурхайг түшиглэсэн "Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор"-ын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, явц, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан;
4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг батлуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, явц, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан
5. Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолойн төсөл, Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станцын төслүүдийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан;
6. Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн хөрөнгө оруулагч "Орано Майнинг С.А.С" компани хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний дагалдах гэрээнүүд болох "Орд ашиглалтын гэрээ, Хувьцаа эзэмшигчийн гэрээ"-ний төслийг эцэслэн боловсруулж, 2025 оны 3 дугаар улиралд багтаан;
7. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төслийн барилга угсралтын зураг төслийн явц, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан;
8. "Гашуунсухайт-Ганцмод", "Ханги-Мандал", "Шивээхүрэн-Сэхээ" хилийн боомтуудын хил дамнасан холболтын, Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн замын бүтээн байгуулалтын төслүүдийн хэрэгжилтийн явцыг сар тутамд;
9. Сэргээгдэх эрчим хүч, тархмал эх үүсвэр бүхий эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг тус тус холбогдох хүмүүст хариуцуулсан байна.

²⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432326041962>

Мөн тус хуралдаанаас гарсан шийдвэрийн тухай Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Учрал дараах мэдэгдлийг хийсэн байна.²⁷ Тэрбээр эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа энэ үед төрөөс хэрэгжүүлэх төслүүдийг ач холбогдол, үр нөлөөгөөр нь эрэмбэлж, илүү оновчтой сонголт хийх шаардлагатай байгааг онцолсон байна. Энэ хүрээнд Азийн хөгжлийн банктэй хамтран боловсруулсан шинэ аргачлалаар хөгжлийн төслүүдийг дөрвөн бүлэг, арван дөрвөн шалгуураар үнэлнэ. Энэхүү үнэлгээ нь макро эдийн засгийн нөлөө, төслийн бэлэн байдал, санхүүжилтийн боломж, нийгмийн үр өгөөж гэсэн дөрвөн чиглэлээр хийгдэх ба төсөвлөлт, хөрөнгө оруулалтын шийдвэр илүү нарийвчлалтай болох ач холбогдолтойг дурдсан байна.

Энэ үнэлгээний үр дүнд 14 мега төслийн дөрөв нь УИХ-аар батлагдаж, хэрэгжиж эхэлсэн байна. Үүнд төмөр замын хил холболтын төсөл, Газрын тос боловсруулах үйлдвэр, Монгол-Францын хамтарсан “Орона майнинг” төслийн хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл багтаж байгаа юм. Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй гол төслүүдэд Тавантолгойн цахилгаан станц, зэс боловсруулах үйлдвэр, гангийн цогцолбор, алт цэвэршүүлэх үйлдвэр, нүүрс болон кокс химийн цогцолбор багтаж байна. Мөн Хэрлэн Тоонот, Орхон Онги, Эгийн голын УЦС зэрэг сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон үндэсний хиймэл дагуул, төмөр замын шинэ төслүүд бэлтгэл шатандаа ажиллаж явааг мэдэгдсэн байна.

Азийн хөгжлийн банктэй хамтран боловсруулсан энэхүү 4 бүлэг, 14 шалгуур бүхий шинэ үнэлгээний аргачлал нь төсөл тус бүрийн эдийн засгийн болон нийгмийн үр өгөөжийг бодитой харьцуулж, төсөвт үзүүлэх нөлөөг илүү нарийвчлан тооцох боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг шинжлэх ухаанч, дата суурьтай болгох, төслүүдийг эрэмбэлэх, нөөцийг оновчтой хуваарилах үндэс, суурь тавигдах боломжтой. Мөн мега төслүүдийн удаашралтай явц, санхүүжилтийн тодорхойгүй байдал, ил тод бус менежментийн тогтолцоог засах зорилготой чухал алхам болж байна.

²⁷ <https://news.mn/r/2813872/>

4. OC4IDS, PIMA АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Дэд бүтцийн мега төслүүдийн ил тод байдал, төлөвлөлт, хэрэгжилтийн үр ашиг нь төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалт татах чадвар, олон нийтийн итгэлцэлд шууд нөлөөлдөг. Тиймээс олон улсын түвшинд өргөнөөр ашиглагддаг хоёр чухал аргачлал болох OC4IDS болон PIMA-г ашиглан Монгол Улсын Засгийн газрын 14, нийслэлийн 24 мега төслийг үнэлж харьцуулсан болно.

4.1 АРГАЧЛАЛУУДЫН ТУХАЙ

Дэд бүтцийн төслүүдийн өгөгдлийн нээлттэй байдлын стандарт буюу Open Contracting for Infrastructure Data Standard (OC4IDS)

OC4IDS нь дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилтийн мөчлөгийн турш дахь мэдээллийг ил тод, нээлттэй, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэхийг зорьдог олон улсын өгөгдлийн стандарт юм. Энэхүү стандартыг Open Contracting Partnership (OCP) болон CoST – the Infrastructure Transparency Initiative хамтран боловсруулсан.²⁸

OC4IDS нь дараах дөрвөн үндсэн үе шатны мэдээллийг цуглуулж, харьцуулж, хянах боломжийг олгодог:

1. Planning (Төлөвлөлт) – Төслийн зорилго, байршил, хугацаа, төсөв
2. Preparation (Бэлтгэл шат) – ТЭЗҮ, Байгаль орчны үнэлгээ, зөвшөөрөл
3. Procurement (Худалдан авалт) – Тендерийн зар, шалгаруулалт, гэрээ
4. Implementation (Хэрэгжилт) – Ажлын явц, гэрээний өөрчлөлт, тайлагнал

OC4IDS нь Open Contracting Data Standard (OCDS)-ийн дэд формат бөгөөд JSON бүтэц дээр үндэслэсэн өгөгдлийг автоматаар нэгтгэх боломжийг олгодог.

Улсын салбарын хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ буюу Public Investment Management Assessment (PIMA)

PIMA нь Олон улсын валютын сан(IMF)-гийн боловсруулсан, улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийн институцийн чадавхыг үнэлэхэд зориулагдсан аргачлал юм.²⁹ Энэхүү аргачлал нь төсвийн үр ашиг, өрийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын удирдлагын зохистой байдлыг үнэлэхэд өргөн хэрэглэгддэг.

PIMA нь хөрөнгө оруулалтын мөчлөгийг гурван үндсэн үе шат болгон ангилж, нийт 15 үзүүлэлт дээр тулгуурлан үнэлдэг.

Хүснэгт 11. Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын үе шатууд

Үе шат	Үзүүлэлтүүд (жишээ)
1. Төлөвлөлт (Planning)	Хөрөнгө оруулалтын стратеги, дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө, төсвийн бодлоготой уялдаатай байдал
2. Хуваарилалт (Allocation)	Төслийн сонголт, эрэмбэлэлт, техник, эдийн засгийн үнэлгээ, эрсдэлийн менежмент
3. Хэрэгжилт (Implementation)	Худалдан авалт, аудит, гүйцэтгэлийн хяналт, тайлагнал

PIMA үнэлгээ нь тухайн улсын төрийн хөрөнгө оруулалтын засаглалын чадавх болон нээлттэй байдлыг оноогоор илэрхийлж, улс орнуудын хооронд харьцуулах боломж бүрдүүлдэг.

OC4IDS ба PIMA нь тус тусын зорилго, бүтэц, ашиглалтаараа ялгаатай ч нийтийн хөрөнгөөр санхүүжих дэд бүтцийн төслийн ил тод байдал ба үр ашгийг сайжруулахад нийтлэг ашиглагддаг. OC4IDS нь төслийн өгөгдлийн стандарт ба мэдээллийн ил тод байдлыг дэмждэг бол PIMA нь институцийн засаглалын үнэлгээ хийж, бодлогын зөвлөмж гаргах үндэс болдог онцлогтой.

Монгол Улсад эдгээр аргачлалыг мега төслүүдийн үнэлгээ, хяналт-шинжилгээ, бодлого боловсруулахад нэвтрүүлэх нь ил тод байдал, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

²⁸ <https://standard.open-contracting.org/infrastructure/>

²⁹ <https://www.imf.org/en/Topics/Governance/Public-Investment-Management-Assessment>

4.2 МЭДЭЭЛЛИЙН ХЯЗГААРЛАЛТ

Мега төслүүдийн талаар олж авсан дараах мэдээллүүд нь OC4IDS ба PIMA үнэлгээний шалгуурт харгалзах боломжтой бөгөөд эдгээрт суурилан товч үнэлгээ хийсэн болно.

Хүснэгт 12. OC4IDS ба PIMA үнэлгээний шалгуур

Стандарт	Шалгуур	Энэхүү судалгаанд багтсан үзүүлэлтүүд
OC4IDS	Төслийн тодорхойлолт (зорилго, байршил, үе шат)	Төслийн нэр, Төслийн зорилго, Хэрэгжүүлэх үе шат, Байршил
OC4IDS	Санхүүжилт ба эх үүсвэр	Санхүүжилтийн эх үүсвэр, Батлагдсан төсөв
OC4IDS	Хэрэгжилтийн байдал	Төслийн хэрэгжилтийн байдал, Үйл ажиллагааны тайлан байгаа эсэх
OC4IDS	Техникийн баримт бичиг	Техник, эдийн засгийн үнэлгээ, Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл
OC4IDS	Гэрээ, худалдан авалт	Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалт, Ханган нийлүүлэх гэрээ
PIMA	Бодлого, шийдвэр	Төсөл баталсан шийдвэр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан эсэх
PIMA	Санхүү, хяналт	Санхүүгийн тайлан, Зарцуулалтын төлөвлөгөө, Аудитын дүгнэлт

OC4IDS ба PIMA үнэлгээний 10 үндсэн шалгуураас Засгийн газрын болон нийслэлийн мега төслүүдийн хувьд 7–8 шалгуурт нийцэх мэдээлэл ил байна. Гэрээний гүйцэтгэл, ханган нийлүүлэгчдийн жагсаалт, гэрээний дүн, худалдан авалтын процессын шатлалын дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг байна.

Ашигласан аргачлалуудын хүрээнд мега төслүүдэд иж бүрэн үнэлгээ хийхэд шаардлагатай дараах мэдээлэл тодорхойгүй буюу зөвлөх багт нээлттэй бус байв.

Хүснэгт 13. OC4IDS ба PIMA үнэлгээ хийхэд ил болгох шаардлагатай мэдээлэл

Шаардлагатай мэдээлэл	Зориулалт	Мэдээллийн зохих эх сурвалж
Гэрээний бүрэн эх (contract text, award notice)	OC4IDS гэрээний ил тод байдлын үндсэн шалгуур	Засгийн газрын худалдан авах ажиллагааны портал
Худалдан авалтын огноо, тендерийн төрөл	Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалт (OC4IDS)	E-procurement систем
Эрсдэлийн үнэлгээ, институцийн хариуцлага	PIMA institutional capacity үнэлгээ	Төслийн бодлогын баримт бичиг, тайлан
Санхүүжилтийн гэрээ, баталгаа, батлан даалтын мэдээлэл	PIMA-ийн төсөвт суурилсан хуваарилалтын шалгуур	Сангийн яам, ЭЗХЯ
Хяналт-шинжилгээний тайлан, үр дүнгийн индикатор	PIMA хэрэгжилтийн хяналт	Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд болон Засгийн газар, нийслэлийн ЗДТГ-т нэгтгэгдэн гарах ёстой.

4.3 ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

OC4IDS нь төслийн хэрэгжилтийн мөчлөгийн түрш (төлөвлөлт, худалдан авалт, хэрэгжилт) бий болох мэдээллийг ил тод, стандартчилагдсан байдлаар олон нийтэд хүргэхийг шаарддаг.

Мега төслүүдэд хийсэн OC4IDS үнэлгээний үндсэн үр дүн:

- Төслийн зорилго, байршил, санхүүжилтийн хэлбэр, хэрэгжилтийн байдал зэрэг суурь мэдээлэл төслүүдийн 80-90 хувьд бүртгэгдсэн.
- Гэрээний ил тод байдал, ханган нийлүүлэгчийн жагсаалт, худалдан авалтын процессын дэлгэрэнгүй мэдээлэл нийт төслүүдийн 20 хүрэхгүй хувьд хангалттай хэмжээнд байна.
- Улаанбаатар хотын төслүүдийн гэрээний болон худалдан авалтын мэдээллийн ил тод байдал хангалтгүй.
- Засгийн газрын төслүүд илүү стратегийн ач холбогдолтой ч техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, олон талт зөвшилцлийн ил тод байдал дутмаг байна.

PIMA нь хөрөнгө оруулалтын үр ашигтай удирдлагыг төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжилт гэсэн 3 шат, нийт 15 шалгуураар үнэлдэг.

Мега төслүүдийн PIMA үнэлгээний үндсэн үр дүн:

- Бодлогод суурилсан төлөвлөлт, шийдвэр гаргалт (policy-based investment decisions): Засгийн газрын төслүүд харьцангуй сайн дэмжигдсэн: 14 төсөл бүгд УИХ-аар батлагдаж, 5 нь 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан.
- Төслийн үнэлгээ, сонголт, нөөцийн хуваарилалт (project appraisal and selection): Засгийн газрын мега төслүүдэд техник, эдийн засгийн үндэслэл хийсэн байдал (71%) дунд түвшинд байгаа ч нийслэлийн төслүүдэд (46%) энэ үзүүлэлт сул.
- Хэрэгжилтийн шат (procurement, monitoring, audit): тайлангийн ил тод байдал, аудитын дүгнэлт, ханган нийлүүлэлтийн гэрээний мэдээлэл аль аль бүлгийн хувьд ихээхэн дутмаг байна.

5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газар болон нийслэл Улаанбаатар хотоос зарласан нийт 38 мега төслийн нэгдсэн зураглал нь төрийн болон орон нутгийн түвшинд томоохон төсөл хэрэгжүүлэх бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн чадавхад олон талын дутагдал, сорилт байгааг харуулж байна. Open Contracting for Infrastructure Data Standard (OC4IDS), мөн Олон улсын валютын сангийн Public Investment Management Assessment (PIMA) аргачлалд тулгуурлан төсөл тус бүрийн өгөгдлийг нэгтгэж, ерөнхий үнэлгээ хийхэд дараах нийтлэг төлөв ажиглагдаж байна. Үүнд:

1. Төсөл хэрэгжилтийн байдал хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай. Засгийн газрын төслүүдийн тал орчим нь хэрэгжиж эхэлсэн ч дийлэнх нь он удаан жилээр яригдсан, үлдсэн хэсэг нь чухам хэзээ хэрэгжих нь тодорхойгүй байна. Нийслэлийн төслүүдийн ихэнх нь зөвхөн судалгаа, бэлтгэл, төлөвлөлтийн шатанд буюу нэг ч төсөл бүрэн хэрэгжилтийн шатандаа ороогүй байна. Энэ байдал нь нийслэлийн мега төслүүд 2040 он хүртэл хэрэгжихээр төлөв харагдаж байна.
2. Ил тод байдал хангалтгүй байх дутагдал төсөл бүрд ажиглагдаж байна. Үйл ажиллагааны тайлан нийт төслийн 92 хувьд байхгүй, сонгон шалгаруулалтын мэдээлэл төслийн талаас илүү хувьд ил биш, олон нийттэй хийсэн хэлэлцүүлэг, нутгийн иргэдтэй байгуулсан зөвшилцлийн баримт бичиг бараг бүх төслийн хувьд бүртгэгдээгүй байна. Энэ нь төслүүдийн үр ашиг, хариуцлагын тогтолцоонд эргэлзээ үүсгэж, хөрөнгө оруулагч болон иргэдийн итгэлийг алдагдуулах эрсдэлтэй.
3. Санхүүгийн баталгаа сул буюу зарласан төслүүдийн дийлэнх нь багцаа эсвэл урьдчилсан ТЭЗҮ-ээр тооцсон төсөвтэй ч тухайн төсвийн эх үүсвэр тодорхойгүй, баталгаажаагүй байна. Тодруулбал, нийт 23.2 их наяд төгрөгийн төсөв бүхий Засгийн газрын 9 төсөл, 38.8 их наяд төгрөгийн төсөв бүхий нийслэлийн 14 төсөлд санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй хэвээр байна.
4. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, менежментийн тогтолцоо сул, төслийн дийлэнх олонхын хувьд энэ чиглэлийн үнэлгээ, төлөвлөгөө хийгдээгүй эсвэл бүртгэгдээгүй байна. Үүнээс үүдэн мега төслүүдийн хэрэгжилт байгаль орчны хууль, тогтоомж, олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөх эрсдэлтэй.
5. Энэхүү тойм зураглалын үр дүн нь Монгол Улсад томоохон төсөл хэрэгжүүлэх институцийн чадавх, бодлогын уялдаа холбоо, хөрөнгө оруулалтын орчны итгэлцлийн түвшин, хяналт-шинжилгээ, тайлагналын стандарт зэрэг систем сул байгааг харуулж байна.

Зураглалд үндэслэн цаашид мега төслүүдийн менежментийг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжүүдийг дэвшүүлж байна.

I. Бодлогын уялдаа, төлөвлөлтийн чанарыг сайжруулах:

- Төслүүдэд хөгжлийн бодлогын баримт бичгийн үе шат, шаардлагыг бүрэн дагаж мөрдөх;
- Мега төслүүдийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн заалтын дагуу үндэсний болон салбарын хөгжлийн баримт бичгүүдтэй уялдуулан батлах;
- Зорилго, үр дүн, шалгуур үзүүлэлт, эрсдэл, санхүүжилтийн загвар зэрэг элементүүдийг бүрэн тодорхойлж, бодлогын баримт бичигт тусгах;
- Нэгдсэн дүн шинжилгээ, эрэмбэлэлтийн тогтолцоог хэрэгжүүлэх;
- Мега төслүүдийг төсвийн хүрээнд уялдуулах “нэг цонхны үнэлгээний тогтолцоо” бий болгож, техникийн үндэслэл, санхүүжилтийн чадавх, нийгмийн хэрэгцээ зэргээр эрэмбэлэх журам хэрэгжүүлэх;
- УИХ ба НИТХ-аар төслийг хэлэлцэн батлах эрх зүйн зохицуулалтыг чанд мөрдүүлэх;
- Нийслэлийн төслүүдийг албан ёсны баримт бичгээр баталгаажуулахгүйгээр хэрэгжүүлэхээс татгалзах.

II. Ил тод байдлыг системчилсэн шинэчлэлээр бататгах:

